



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/65

Мөрөн сум

Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн  
бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн бүтэц орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү захирамжийн дагуу байгууллагын 2024 оны цалингийн санд багтааж зохицуулалт хийхийг Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Октябрьбаяр)-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийг албажуулснаас хойш ажлын 3 өдөрт багтаан албан хаагчдад танилцуулж, шийдвэрийг мэдэгдсэн талаар баримт бүрдүүлж, бүтцийн өөрчлөлтөд орж байгаа албан хаагчдад хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлж ажиллахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Октябрьбаяр)-д үүрэг болгосугай.

4.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/366 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 16-ны өдрийн 43 дугаар  
захирамжийн хавсралт

АХМАД НАСТНЫ АСРАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Төвийн дарга	1
2	Архив, бичиг хэргийн ажилтан	1
3	Нягтлан бодогч	1
4	Нярав	1
5	Уламжлалын их эмч	1
6	Сувилахуйн арга зүйч	1
7	Нийгмийн ажилтан	1
8	Сэтгэл зүйч	1
9	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан	1
10	Эрх зүйч	1
11	Ахлах тогооч	1
12	Ээлжийн тогооч	3
13	Үйлчилгээний ажилтан	4
14	Хувцас, цагаан хэрэглэл угаагч	1
15	Үйлчлэгч	1
16	Цахилгаанчин, сантехникч	1
17	Харуул хамгаалалтын ажилтан	4
	Нийт	25

оОо